

Засаг дарга

Батлав

Г.Алтанхуяг

2024 оны 05 сарын 05-ны өдөр

**БЭЛЧЭЭРИЙН ИНЖЕНЕРИЙН
ХИЙЦТЭЙ ГҮН ӨРМИЙН ХУДАГ ШИНЭЭР ГАРГАХ АЖЛЫН ТЕХНИКИЙН
ТОДОРХОЙЛОЛТ.**

Архангай аймгийн Жаргалант сумын Хоолт багт бэлчээрийн инженерийн хийцтэй гүн өрмийн 2 худаг шинээр гаргах техникийн тодорхойлолт.

Худалдан авах ажиллагааны зорилго: Хүн ам, мал сүргийг бэлчээрийн болон ундны усан хангамжаар хангах.

Зохион байгууллагч: Архангай аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газар

Байршил: Архангай аймгийн Жаргалант сумын Хоолт багт

Хөрөнгө оруулалт: Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөс бэлчээрийн 2-р худаг тус бур 30.000.000 /сая төгрөг/ нийт 60.000.000 /сая төгрөг/

Ажлын гүйцэтгэл, тавигдах шаардлага: Инженерийн хийцтэй худгийн техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага

- Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага MNS 6088:2011 стандартын дагуу өрөмдлөг, шавхалт, туршилтийн ажлыг явуулах, худгийн усны шахуурга, цахилгаан үүсгүүрийг сонгон суурилуулах, худгийн барилга барих ажлыг гүйцэтгэнэ.
- Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 101/189/194 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам"-ыг мөрдөнө.
- Худгийн цооног өрөмдөх зөвшөөрөлийг худгийн ажил эхлэхээс өмнө аймгийн БОАЖГазраас авна.
- Худгийн үзүүлэлт болон хөрөнгө оруулалт, гүйцэтгэгчийн мэдээллийг харуулсан гадна хаягийг холбогдох журмын дагуу хийж хадна.

№	Үзүүлэлтүүд	Тендерт оролцогчийн санал
1	Цооног өрөмдөх, цооногийг тоноглох, шавхалт	
1.1	Шинэ худгийн цэг тогтоох хайгуулын ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх тухай албан ёсны гэрээ байгуулсан байх, хэрэв өрөмдлөгийн компани өөрсдөө энэ ажлыг гүйцэтгэх бол зөвшөөрөлтэй байх бөгөөд эрсдэлийг хариуцаж, ямар хайгуулын арга хэрэглэх тухай танилцуулга ирүүлнэ.	
1.2	Цооногийн ашиглалтын ундарга: 2м ³ /цаг-6м ³ /цаг ус өгөх хүчин чадалтай байна.	
1.3	Суултын яндангийн материал нь ган, хуванцар хоолой байх ба ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн олон улсын чанарын гэрчилгээтэй байна.	
1.4	Шүүрийн яндангийн материал нь ган, хуванцар хоолой байх ба ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн олон улсын чанарын гэрчилгээтэй байна.	
1.5	Цооногоос ус өргөх яндангийн диаметр 32 мм-ээс багагүй, материал нь темөр болон ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой ISO /хүйтний улиралд тэсвэртэй/	
1.6	Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 10-15 мм-ээс томгүй байна.	
1.7	Тунгаагуурын гүн: 2м-ээс багагүй	